



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/520

Мөрөн сум

Тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.6-ийн "г" заалт, Төсвийн тухай хуулийн 14.2.3, 65.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны ээлжит XI хуралдааны 05 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мөрөн сумын иргэдээс ирсэн өргөдөл, хүсэлт, амьдралын боломж, нөхцөлийг харгалзан үзэж 1 дүгээр багийн иргэн Н.Цэнд-Аюуш, Д.Сосорбарам, 6 дугаар багийн иргэн Б.Наранцэцэг, Ж.Хумбантоого, Н.Буянхишиг, Ж.Байгальмаа нарт тус бүр 200,000 /Хоёр зуун мянга/ төгрөг, 7-р багийн иргэн Ё.Отгонбаяр, Н.Гарамсүрэн, М.Цолмон, 6 дугаар багийн иргэн Н.Пүрэвдулам нарт тус бүр 100,000 /Нэг зуун мянга/ төгрөгийн тусламж үзүүлсүгэй.

2. Дээрх иргэдэд олгох 1,600,000/ Хоёр сая нэг зуун мянга/ төгрөгийн хөрөнгийг "Зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн хамгааллын үйлчилгээг үзүүлж, амьдрах орчныг сайжруулах" төсөл, арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Э.Аззаяа, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Базар/ нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д даалгасугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД